

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Нийслэлийн боловсрол 2020” дэд хөтөлбөр батлах тухай А/81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлээс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдын бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулах, бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: -Нийслэлийн Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч - Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаа

Гишүүд: -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Эрдэнэжаргал;  
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү;  
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр;  
-Нийслэлийн Боловсролын газрын дарга Ж.Гантулга;  
-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг;  
-Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр;  
-Нийслэлийн Статистикийн газрын дарга Ц.Заяхүү.

Нарийн бичгийн дарга: -Нийслэлийн Боловсролын газрын орлогч дарга Л.Дашдэмбэрэл.

2. Цахим бүртгэлийг чанартай зохион байгуулж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /Ш.Анхмаа /-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН  
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН